

ТӨВ АЙМГИЙН 2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2023 оны 07 сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2023 оны 06 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ, Ажлын албанаас 2023 оны 06 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

I. Аймгийн ИТХ болон Зөвлөлийн хүрээнд:

Аймгийн ИТХ-ын 15 дугаар хуралдаан 2023 оны 06-р сарын 29-ний өдөр, Хурлын Зөвлөлийн ээлжит 3-р хуралдаан 6-р сарын 20, ээлжит бус 4-р хуралдаан 06-р сарын 28-ны өдөр тус тус хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын XV хуралдаанаар:-

1.Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан “Төв аймаг”-ийг төрийн дээд шагналд тодорхойлох тухай асуудлыг хэлэлцээд Улс эх орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр тасралтгүй хангах үүргээ олон жил нэр төртэй хэрэгжүүлэн, улсын хэмжээний жилийн нийт хэрэгцээт үр тарианы 22, төмсний 62.9, хүнсний ногооны 16.5, таримал тэжээлийн 50.2 хувийг тус тус хангаж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг хөгжлийн шинэ шатанд гаргах хөрс суурийг бүрдүүлэн тус салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, иргэдээ орон нутагтаа тав тухтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэн, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын олон төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэн, ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг ханган, нэгжээс хураан авах үр тариа, нийт хураан авсан төмсний ургацаараа манай аймаг улсдаа тогтмол тэргүүлээд байгаа бөгөөд үндэсний хэмжээний эдийн засагт оруулсан үнэтэй хувь нэмэр, нийгэм, хүмүүнлэгийн салбарт гаргасан амжилт, Төв аймгийн иргэд, хөдөлмөрчид, тариаланчид, малчдын оруулж байгаа хувь нэмрийг өндрөөр үнэлж, Ардын хувьсгалын 102, Богдхан уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн баатар цол”-оор шагнуулахаар шийдвэрлэн Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

2.Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцээд аймгийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхээр төрийн болон төрийн бус байгууллага, бүхий л байгууллагууд сэтгэл, зүтгэл гарган ажиллаж байгааг тэмдэглээд үлдэж буй хугацаанд төлөвлөгөөний хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ болон төлөөлөгчдөөс гарсан саналыг тусган эрчимжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

3.Аймгийн 27 сумын 97 багийн нэр батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор УИХ-аар батлуулахаар санал уламжилсан тогтоолыг ГЗБГЗЗГ-т хүргүүлэхэд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зөвшөөрөл авах чиглэлийн дагуу 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн ХЭГ/2973 дугаар албан бичгээр манай аймгийн 27 сумын 97 багийн оноосон нэрийг зөвшөөрсөн.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэрийг иргэний үнэмлэхийн хаягийн бүртгэл, үл хөдлөх хөрөнгийн байршлын хаяг, хуулийн этгээдийн хаягийн бүртгэлд тэмдэглэдэг бөгөөд багийн хаягийн мэдээлэл Сонгуулийн үйл ажиллагаа, эрүүл мэнд, банк санхүү, боловсрол, харилцаа холбоо, эрчим хүч зэрэг 20 гаруй төрлийн төрийн үйлчилгээнд зайлшгүй хэрэглэгддэг тул багийн нэрийг батлах нь зүйтэй гэж үзэн Төв аймгийн 27 сумын 97 багийн дугаар, нэрийг батлав.

4.Улсын тусгай хэрэгцээний газрын хилийн заагт өөрчлөлт оруулах санал уламжлах тухай асуудалд: Төв аймгийн нутаг дэвсгэрт үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын зориулалтаар сүүлийн жилүүдэд хэд хэдэн байршилд ихээхэн хэмжээтэй газруудыг улсын тусгай хэрэгцээнд авч, тухайн газруудын нөлөөлөлд өртөж буй иргэн, аж ахуйн нэгжийн газрыг чөлөөлөх ажлыг орон нутаг зохион байгуулан ажиллаж байгааг тэмдэглээд Майдар хотын бүтээн байгуулалтын хүрээнд 12000 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан Засгийн газрын 2018 оны 273 дугаар тогтоолын хавсралт, Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 19390.4 га

газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан Засгийн газрын 2021 оны 307 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах саналыг уламжлахаар шийдвэрлэв.

Засгийн газрын 2018 оны 273 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах саналын солбицлыг нэгдүгээр хавсралтаар, Засгийн газрын 2021 оны 307 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах саналын солбицлыг тогтоолын хоёрдугаар хавсралтаар тус тус батлав.

Улсын тусгай хэрэгцээний газрын хилийн заагт өөрчлөлт оруулах саналыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлэх, улсын тусгай хэрэгцээнд байгаа газрыг чөлөөлөхөд тухайн орон нутгийн иргэн, аж ахуй нэгжийн 52,3 тэрбум төгрөгийн нөхөх олговрын асуудлыг 2024 оны улсын төсөвт тусгуулан шийдвэрлэх асуудлыг Монгол Улсын Засгийн газарт уламжлахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

5. Аймгийн нутаг дэвсгэрт хууль бус олгосон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл цуцлуулах тухай асуудлыг хэлэлцээд Төв аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын 201.3 мянган га газарт 79, ашиглалтын 160.8 мянган га газрыг хамарсан 304 тусгай зөвшөөрөл олгогдсоноос ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 30 хувь нь үйл ажиллагаа явуулж, 23 хувь нь газрын төлбөр төлж байгаа бөгөөд 2013-2022 онд аймгийн Засаг даргын саналгүй 124.8 мян.га газрыг хамарсан ашиглалтын 105 тусгай зөвшөөрөл, 2015-2016 онд “Ашигт малтмалын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтыг зөрчиж орон нутгийн саналгүй 17.9 мян.га газрыг хамарсан хайгуулын 12 тусгай зөвшөөрөл олгосон, 2018 онд Ашигт малтмал, газрын тосны газраас 26 сумын 516.6 мянган га газрыг хамарсан нутаг дэвсгэрт сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай ирүүлсэн мэдэгдэлд дурдсан талбай нь иргэний өмчлөл болон өрхийн өвөлжөө, хаваржаа, тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн 832.4 га, Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолоор “Тариалангийн бүс нутаг”-аар тогтоосон 10877,04 га газар, бэлчээрийн болон тариалангийн 6 худаг, түүх соёлын дурсгалт газар, булаг шанд, гол горхи, ойн сан бүхий газруудыг тус тус хамарсан буюу давхцаж байгааг холбогдох сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох саналыг дэмжих боломжгүй санал хүргүүлсэн боловч 2018-2023 онд 16 сумын 26 байршлын 113885.46 гектар талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон тул “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийг хангаж, геологийн хайгуул, судалгаа, ашигт малтмал олборлолтыг хууль тогтоомж, орон нутгийн эрх ашиг, байгалийн даац чадамжид нийцүүлэн явуулах зорилгоор хавсралтад дурдсан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт уламжилахаар шийдвэрлэв.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны энэхүү тогтоол, холбогдох бусад баримт материалыг Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” болон холбогдох бусад хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой тавих хяналтыг сайжруулж, хайгуул, олборлолтын үйл ажиллагааны улмаас хөндөгдсөн газрын нөхөн сэргээлтийг стандарт, шаардлагын дагуу хийлгэн хүлээн авах, хууль зөрчигчдөд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны шийдвэрийг үл харгалзан шийдвэр гаргаж буй байдлыг холбогдох төрийн төв байгуулагуудад уламжилж таслан зогсоох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргад даалгав.

6. Зуунмод, Сэргэлэн сумын хилийн цэсийг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцээд Зуунмод сумын ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хилийн цэсэд өөрчлөлт оруулах саналын газрын хэмжээг дахин багасгаж Ажлын хэсгийн хурлын үеэр гарсан 429 га-аар нэмэгдүүлэх буюу нийт 2347 га болгох саналыг ирүүлсний дагуу Сэргэлэн сумын ИТХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 19 дүгээр хуралдаанаар хэлэлцээд дэмжих боломжгүй талаар 63 дугаар тогтоол ирүүлжээ. Монгол Улсын хэмжээнд газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг нэгдсэн тогтолцоонд шилжүүлснээр Зуунмод сумын Зүүндэлгэр багийн иргэд, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлийн газрын мэдээлэл болон иргэдийн үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх боломжгүй болж, хууль ёсны эрх нь зөрчигдөж байгаатай холбогдуулан, Зуунмод сумын иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг дэмжин Монгол Улсын Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.

Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумдын хиллэх хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг нэгдүгээр хавсралтаар, Зуунмод, Сэргэлэн сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах нутаг дэвсгэрийн газрын зургийг хоёрдугаар хавсралтаар, Сэргэлэн,

Зуунмод сумын нутаг дэвсгэрт оруулах өөрчлөлтийн тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус батлав.

7. Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлийн шинээр авах хүсэлтийн тухай асуудал, энэ талаар Ашигт малтмал газрын тосны газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн дүгнэлт, лавлагаа, Алтанбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоол, аймгийн Эрдэс баялгийн зөвлөлөөс хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг дэмжсэн тухай гаргасан шийдвэрийг хэлэлцээд хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дэмжих боломжтой гэж үзэн “Санал өгөх тухай” тогтоолыг батлав.

8. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн зарим тогтоол шийдвэрүүдийн тухай өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Газрын харилцаа байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт аймаг, сумын эрх бүхий албан тушаалтнуудаас гаргаж байгаа захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, давхардал, зөрчлийг арилгах зорилт, арга хэмжээг тусган хэрэгжилтийг хангах, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, болон бусад хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн 4 тогтоол, журмын төслийг шинэчлэн боловсруулж, иргэд олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулан нөлөөллийн шинжилгээ хийж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр уламжилсаныг тэмдэглээд “Байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээ тогтоох тухай” тогтоолыг батлав.

Аймгийн хэмжээнд судалгаа шинжилгээний, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах байгалийн ургамлын нөөцийн төлбөрийг экологи-эдийн засгийн үнэлгээнээс тооцох ургамлын жагсаалтыг нэгдүгээр, төлбөрийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус батлан иргэн аж ахуйн нэгж, байгууллагад нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгаа шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглуулахаар тогтоов.

Тус тогтоолын 1 дүгээр заалтад заасны дагуу байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийг бүрэн ногдуулж, сумын төсөвт төвлөрүүлэн хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад даалган тогтоолын хоёрдугаар хавсралтад тусгагдаагүй байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тогтоох болон тогтоогдсон төлбөрийг ургамлын тархац, нөөцийн байдлыг харгалзан өөрчлөн тогтоохдоо тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан хувьд багтаан тогтоож, нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөв.

-Рашаан ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 03 дугаар тогтоолыг шинэчлэн батлах эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашиглах шаврыг хүн хоног тутам 500 төгрөг болгон тогтоох, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх тухай мэдээллийг хэлэлцээд “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хууль, 3.2-т “Эмчилгээний зориулалттай шавар, элсийг ашиглахтай холбогдсон харилцааг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна”, Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2020.04.28 А/301, А/265 дугаар хамтарсан “Рашааныг зохистой ашиглах журам” тушаалыг үндэслэн Төв аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашаан ус ашигласны төлбөр ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Рашаан ашигласны төлбөрийн хэмжээ тогтоох тухай” тогтоолыг шинэчлэн хавсралтын хамт батлав.

Төлбөрийн хэмжээ тогтоох талаар батлагдсан дээрх тогтоолуудыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд үүрэг болголоо.

-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг шинэчлэн батлах тухай мэдээллийг хэлэлцээд энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах (иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны бохирдолыг багасгах, урьдчилан сэргийлэх үүднээс иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, сэргээн ашиглах, дахин

боловсруулах, тээвэрлэн устгах, төвлөрсөн хогийн цэг талбайд ландфил аргаар газарт булшлахтай холбогдон гарах харилцааг зохицуулах) Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зорилгоор “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг шинэчлэн батлав.

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Хог хаягдлын менежментийг сайжруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг шинэчлэн батлах тухай мэдээллийг хэлэлцээд хог хаягдлыг мезежментийг сайжруулахад хаягдалгүй техник, технологи нэвтрүүлсэн, хог хаягдлаа бууруулсан, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгахад шинэлэг менежментийг нэвтрүүлсэн хоёрдогч түүхий эдийг цуглуулсан, дахивар нөөц болгон ашигласан, дахин боловсруулсан, эдийн засгийн эргэлтэд оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд урамшуулалд хамрагдах, эрх бүхий байгууллага урамшуулал олгох үйл ажиллагаанд тус журмыг дагаж мөрдөх зорилгоор “Хог хаягдлын менежментийг сайжруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг шинэчлэн батлав.

Дээрх батлагдсан журмуудыг аймгийн хэмжээнд мэдээлж, мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалган тус тогтоолуудыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд үүрэг болгов.

9. “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны мэдээллийг хэлэлцээд 2023-2024 оны халаалтын улиралд хэрэглэгчдийг дулаан хангамжаар хангах асуудлын бэлтгэлийг бүрэн хангаж шаардлагатай арга хэмжээ авч анхаарч ажиллахыг аймгийн Засаг даргад болон холбогдох хэлтэс, мэргэжлийн байгууллагуудад үүрэг болгов.

10.Барилга захиалагч орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны мэдээллийг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

11.Аймгийн Цагдаагийн газрыг төрийн дээд одон медальд тодорхойлох тухай асуудлыг хэлэлцээд Төв аймгийн Цагдаагийн газрыг Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жил, цагдаагийн газрын 80 жилийн ойг тохиолдуулан төрийн дээд шагнал “Цэргийн гавьяаны одон”-оор шагнуулахаар шийдвэрлэн Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

12.Аймгийн ИТХ-ын шагналаар шагнуулах тухай аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн асуудлыг хэлэлцээд Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан, Зуунмод сумын уугуул, Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Алтанбулаг сумын уугуул, UBS телевизийн ерөнхий захирал, найруулагч, хөгжмийн зохиолч Лхагвадоржийн Балхжав, Баянцагаан сумын уугуул, Монгол Улсын Ардын жүжигчин, зууны манлай дуурийн дуучин Аюурзанын Долгор, Баянцогт сумын уугуул, малчин, саальчин, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Самбуугийн Наранцэцэг, Баян-Өнжүүл сумын уугуул, Монгол Улсын гавъяат дасгалжуулагч, Монгол Улсын арслан, ардын багш Лувсанчимэдийн Сосорбарам, Жаргалант сумын Өгөөмөр багийн өндөр настан, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Чимэг-Очирын Шаравдорж, Сэргэлэн сумын уугуул, тод манлай уяач Дамбаржаагийн Онон, Улсын Их Хурлын гишүүн асан, Төв аймгийн нутгийн зөвлөлийн тэргүүн Сундуйн Батболд, Дэлгэрхаан сумын уугуул Харанга хамтлагийн ахлагч, Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн Цэрэндоржийн Чулуунбат, Бүрэн сумын уугуул үйлчилгээний гавъяат ажилтан Баатарын Туул, Зуунмод сумын Баруун Зуунмод багийн иргэн, Монгол Улсын гавъяат жүжигчин, зууны манлай хос дуучин Үржингийн Вандан, Дэмбэрэлийн Дуламсүрэн нарт Төв аймгийн “Хүндэт иргэн” цол хүртээж,

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Үндэсний соён гэгээрүүлэгч, шашин соёлын нэрт зүтгэлтэн, үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгч II Богд Лувсандамбийдонмэ”-н нэрэмжит шагналаар Төв аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Бүрэн сумын уугуул Ширчингийн Сүхбаатарыг, аймагт буддын шашин, соёлыг хөгжүүлэх, энэрэн нигүүлсэхүйн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Зуунмод сумын Дашчойнхорлон хийдийн хамт олныг, Хүүхэд залуучуудын боловсролын хөгжлийг дэмжих, орчин нөхцөлийг сайжруулах, боловсрол соёл, эрүүл мэнд, нийгмийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт, хувь нэмрийг нь үнэлж “Доржгочоо сан”-гийн хамт олныг тус тус шагнахаар шийдвэрлэв.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 15 дугаар Хуралдаанаар 12 асуудал хэлэлцэж 16 тогтоол батлан хуралдааны тэмдэглэлээр 2 үүрэг өгөв.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит III хуралдаанаар:-

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит 3-р хуралдаан 2023 оны 6-р сарын 20-ны өдөр хуралдлаа. Тус Хуралдаанаар:-

1.Аймгийн нутаг дэвсгэрт хууль бус олгосон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл цуцлуулах тухай

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн шинээр авах хүсэлтийн тухай

3.Улсын тусгай хэрэгцээний газрын хил заагт өөрчлөлт оруулах тухай

4.Зуунмод, Сэргэлэн сумын хилийн цэсийг өөрчлөх тухай

5.Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрүүд асуудлуудыг хэлэлцэн Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүллээ.

6.Хот байгуулалтын тухай хуулийн 8.1.1 дэх заалтын дагуу Хот төлөвлөлтийн асуудлыг хэлэлцэн тухайн асуудалтай холбоотой мэдээлэл хангалтгүй гэж үзэн хойшлууллаа.

7.Аймгийн 27 сумын 97 багийн нэрийг батлах тухай

8.Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц

9.ТӨВ ЧАНДМАНЬ-ДЭХГ /ОНӨААТҮГ/ -ын үйл ажиллагааны мэдээлэл

10.Төв аймгийн барилга захиалагч орон сууц корпорацн ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны мэдээлэл

11.Аймгийн Цагдаагийн газрыг төрийн дээд одон медалиар шагнуулахаар уламжлах тухай

12.Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан “Төв-аймаг” -г төрийн дээд шагналд уламжлах тухай асуудлуудыг хэлэлцэн Хурлын Хуралдаанд шилжүүллээ.

13.Аймгийн ИТХ-ын шагналаар шагнах тухай асуудлыг хэлэлцэн шагналд уламжлагдсан сумдын материалын бүрдлийг ханган дараагийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүллээ.

14.Аймгийн ИТХ-ын ээлжит 15-р Хуралдааны тов тогтоож, хэлэлцэх асуудал батлах тухай асуудлуудыг хэлэлцэж аймгийн ИТХ-ын ээлжит 15 дугаар Хуралдааныг 2023 оны 06 сарын 29-ний өдөр хуралдуулах тов тогтоолоо.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит IV хуралдаанаар:-

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит бус-IV хуралдаан 2023 оны 06-р сарын 28-нд хуралдав.

Энэ удаагийн хуралдаанаар:

“Аймгийн ИТХ-ын шагналаар шагнах тухай” асуудлыг хэлэлцэж, Хурлын Хуралдаанд шилжүүлэв.

Аймгийн Засаг даргаас нэмэлтээр өргөн мэдүүлсэн “Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн шинээр авах хүсэлтийн тухай болон “Төв аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” асуудлуудыг дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлууллаа.

III. Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд:

Энэ 6 дугаар сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 45 албан бичиг ирснийг бүртгэн, хариу хүргүүлэх шаардлагатай 15 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.

Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заасны дагуу 2023 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Ням” гарагт улсын хэмжээнд нөхөн сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа. Аймгийн хэмжээнд Бүрэн, Өндөрширээт, Заамар сумдад ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албан хаагчид болон Цагдаа, Улсын бүртгэл, Тагнуулын байгууллагын нийт 93 хүн ажиллаж, дээрх 3 сумын орон гарсан 8 төлөөлөгч согогдлоо.

Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой гэмт хэргийг бууруулах, бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гэмт хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, “Азийн сан” хамтран хууль бус уул уурхайн үйл

ажиллагаа, түүнтэй холбоотой гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлийн хэлэлцүүлгийг 06-р сарын 14-нд зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт аймгийн ИТХ-ын дарга, Ажлын алба, Азийн сангийн Төслийн менежер Л.Байгаль, зөвлөх А.Баянмөнх, Монгол улсын ГХУСАЗЗ-ийн ажлын албаны ахлах мэргэжилтэн Отгонжаргал нар болон Төв аймгийн ГХУСАЗСЗ-ийн гишүүд оролцсон. Төв аймгийн хэмжээнд уул уурхайн үйлдвэрлэл 1990-ээд оноос “Алт” хөтөлбөр хэрэгжүүлснээс хойш эрчимтэй явагдаж одоог хүртэл нийт 10956 га газар хөндөгдсөнөөс уул уурхайн үйл ажиллагааны улмаас хөндөгдсөн талбайн 63.3% -д техникийн, 37.2% -д биологийн нөхөн сэргээлт тус тус хийсэн байна.

Аймгийн ИТХ-аас энэ оны эхний хагас жилд хийсэн ажил, цаг үеийн мэдээлэл, аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн сургалт зохион байгуулах, Төв аймгийн түүхт 100 жилийн ойн арга хэмжээнд ИТХ-ын төлөөлөгчид нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцож, ой угтсан ажил арга хэмжээг идэвхтэй зохион байгуулан манлайлан оролцох, Хурлын бодлого шийдвэрийг эрчимжүүлж ажиллах талаар аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн 27 сумын ИТХ-ын дарга нартай 2023 оны 06-р сарын 09-нд цахим хурал хийж, ажлын чиглэл, зөвлөмж өглөө.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Швейцарын хөгжлийн агентлагын “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөл, Төв аймгийн ИТХ-ын Ажлын алба хамтран 2023 оны 06-р сарын 22-нд аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн нэгдсэн сургалт зохион байгуулж, 27 сумын ИТХ-ын 500 гаруй төлөөлөгч хамрагдлаа. Сургалтаар Бэлчээрийн доройтол, түүнийг даван туулах зүй зохистой менежментэд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, бэлчээр ашиглагчдын холбоо, орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг бий болгох талаар болон асуудал дэвшүүлсэн илтгэлүүдээр мэдлэг, мэдээлэл олгож, улсын хэмжээнд анх удаа аймаг, сумын төлөөллийн байгууллагын бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж зохион байгуулснаараа онцлог болов.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын ажлын хүрээнд:-

Аймгийн ИТХ-ын Ажлын алба, Төв аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссоос 6-р сард хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлж ажиллалаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авах олон нийтийн хэлэлцүүлгийг Төв аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисс, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба хамтран аймгийн хэмжээнд 2023 оны 06 дугаар сарын 05-12-ны өдрүүдэд зохион байгуулав. Хэлэлцүүлэг, санал асуулгыг 8 суманд танхим болон цахим хэлбэрээр, аймгийн хэмжээнд Төв аймгийн ИТХ-ын tov.khural.mn цахим хуудсаар авч, нийт 512 иргэн хамрагдлаа.

Мөн хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3 “Цагаатгуулах тухай гомдлыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй” заалтыг санал асуулгад оролцсон 512 иргэнээс 422 буюу 82.4 хувь нь дэмжиж, 52 буюу 10.2 хувь нь хугацаа сунгах шаардлагагүй гэж үзэн, 7.4 хувь нь ямар нэгэн санал байхгүй гэж хариулж, 80 иргэн тодорхой санал гаргасан байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд:

Эрүү, хэв журмын нөхцөл байдлын мэдээллийг тухай бүр судлан, аймгийн Прокурорын газрын нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн сумдын ГХУАЗСЗ-анхаарах асуудлаар аймгийн ГХУСАЗСЗ-ийн даргын 06, 09 тоот албан бичгээр чиглэл хүргүүлж, сумдын ИТХ-ын дарга нарийн бичгийн дарга нарын сургалт болон бүсийн сургалтад аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа, анхаарах асуудлаар бэлтгэн танилцуулга 5 удаагийн сургалт, мэдээлэл хийв.

Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас санаачлан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчилд өсвөр насны хүүхэд залуучуудыг холбогдохоос урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн мэдлэг, ойлголт, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх аяныг зохион 53 төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг хамруулан нийт 1500 гаруй төлөөлөл танхимаар, 26 сумын 768 иргэн цахимаар хамрагдсан байна.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарь болон цаг үеийн ажлаас шалтгаалан 06 дугаар сарын 05, 12, 26-ны өдрүүдэд танхимаар зохион байгуулж, 79 заалт бүхий холбогдох үүрэг даалгавар өгч хэрэгжилт тооцов.

“Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээг 2023 онд зохион байгуулах хуваарийн дагуу 06 дугаар сарын 07-ны өдөр аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Т.Хуягбаатар оролцлоо.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/87 дугаар захирамжаар баталсан “Аймгийн нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг тооцоход 88,02% байна.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 81 дүгээр тушаалын дагуу томилогдсон ажлын хэсэг 06-р сарын 19-ны өдөр Төв аймагт ажиллаж Төрийн албаны тухай хууль тогтоомж, шинэтгэлийн бодлогын хэрэгжилттэй танилцаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг олон нийтэд сурталчлах, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем дэх мэдээллийн бүрдүүлэлт, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт хийх, мэдээллийн арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах чиг үүргийн хүрээнд ажиллахад аймгийн ИТХ-ын Ажлын алба хамрагдан холбогдох баримт бичгийг хянуулан шалгуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 05 -р сарын 15-ны өдрийн 53-р зарлигаар олон хүүхэд төрүүлж, өсгөн “Алдарт эх” 1,2 дугаар зэргийн одонгоор шагнагдсан Төв аймгийн 304 эхэд одон гардуулах ёслолын үйл ажиллагааг аймгийн ИТХ-ын ажлын алба Монгол туургатан театрт зохион байгууллаа.

Аймаг, сумын хэмжээнд төрийн одон медальд тодорхойлогдсон 148 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ерөнхийлөгчийн тамгын газарт уламжлав.

Аймгийн түүхт 100 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах 12 салбар хороо, 3 дэд хороог аймгийн Засаг даргын 2023.05.16-ны а/329 дугаар захирамжаар томилж салбар хороодын төлөвлөгөө, төсвийг батлуулах ажлыг зохион байгуулж, Салбар хороодын шуурхай хуралдааныг долоо хоног бүрийн лхагва гариг бүрт зохион байгуулж нийт 4 удаа хийж, үүрэг чиглэл өгөв.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/392 дугаар захирамжаар аймгийн 100 жилийн баяр наадмыг зохион байгуулах салбар хороодын төсвийг баталсан.

Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн нэгдсэн болон урлаг соёлын арга хэмжээний хөтөлбөрийг баталж, нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулав.

Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд “Төв 100” пэйж хуудсыг нээн ажилуулж байна. Тус пэйжид тайлант хугацаанд 236 төрлийн мэдээлэл орж, давхардсан тоогоор 260,000 гаруй хандалт аваад байна.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2023 оны 06 дугаар сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **16** байгууллага **600-аад** төрлийн үйлчилгээг **6200 гаруй** иргэнд, өдөрт дунджаар **250-300** иргэнд хүргэн үйлчилжээ.

Цахим үйлчилгээний нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ээр дамжуулан аймгийн хэмжээнд **1703** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **809** лавлагаа үйлчилгээ авсан байна. Мөн E-Mongolia үйлчилгээний тухай заавар зөвлөмжийг, төрийн үйлчилгээг цахимаар авч болох тухай мэдээ мэдээллийг **117** иргэнд хүргэж ажилласан байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **8** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан.

Өөрөө өөртөө үйлчлэх цахим мэдээллийн буланд иргэд өөртөө үйлчлэх зориулалт бүхий газрын албаны киоск машин, төлбөр төлөлтийн “Гэрэгэ” киоск машинуудыг байршуулсан. Мөн Цахим үйлчилгээний нэгдсэн систем www.e-mongolia.mn, Газрын мэдээллийн нэгдсэн сангийн www.egazar.gov.mn, Аймгийн албан ёсны веб сайт www.tov.gov.mn, Аймгийн статистикийн хэлтсийн www.nso.gov.mn сайтуудыг холбосон 4 ухаалаг дэлгэцийг тус тус байршуулан иргэдэд цаг үеийн болон дотоод ажил үйлчилгээтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт **117** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол

Гэрэгэ киоскоор дамжуулан **31** иргэн машины татвар, торгууль, улсын бүртгэлийн лавлагаа, жолоочын хариуцлагын даатгал, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авчээ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Их хурлын 2011 оны 22 дугаар тогтоол “Гамшгаас хамгаалах төрөөс баримтлах бодлого хөтөлбөр, Засгийн газрын 2012 оны 30 тогтоол “Гамшгаас хамгаалах төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, 2015 оны 303 дугаар тогтоол “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр батлах тухай”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/133 дугаар “Заавар батлах тухай” тушаалын хэрэгжилтийг тус тус хангуулах талаар дараахь ажлыг зохион байгуулав. Үүнд:

Улсын Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр албан даалгавар “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг гаргасан.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд аймгийн Засаг даргын А/458 захирамж, үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг гаргуулан ажилласан.

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 05 өдрийн А/375 дугаар захирамж “Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн зохион байгуулах тухай”-аар 2023 оны 06 дугаар сарын 05, 08-ны өдрүүдэд 2 удаа үзлэг зохион байгуулж Мөнх-Алдарын талбайд зохион байгуулж явууллаа. Үзлэгт аймгийн гамшгаас хамгаалах 10 албаны 17 мэргэжлийн ангийн 411 томилгоот бүрэлдэхүүнийг хамруулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит “Иж бүрэн шалгалт”-ыг 2023 оны 06 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд 2020-2022 он, 2023 оны эхний хагас жилийн байдлаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, хэрэгжилтийг шалгуулан ажиллалаа.

Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/292 дугаар захирамжийн дагуу 10 ширхэг Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дуут дохио дамжуулах төхөөрөмж авч Баянчандмань, Баянцогт, Баянхангай, Баян-Өнжүүл, Баянцагаан, Жаргалант 6 сумдад болон Зуунмод сумын 3, 4, 6 дугаар багуудад тараан өгч, Онцгой байдлын газрын хөдөлгөөнт удирдлагын байранд суурилуулсан.

Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/06 дугаар захирамжийн дагуу Газар хөдлөлтийн хөрсний чичирхийллийн хурдатгал хэмжигч багажийг Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвд 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Одон орон геофизикийн хүрээлэнгээс суурилуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан “Шинээр баригдаж байгаа барилга байгууламжид гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”-ийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 20 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гал түймэр болон осол гарч болзошгүй 67-н зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 25 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгч ажилласан. Аймгийн хэмжээнд баригдах 5 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичсэн. Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 30-н аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгож ажиллалаа.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрд урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажилтан, алба хаагчдад танхимын сургалт зохион байгуулж 4 цагийн сургалтаар 75 хүнийг хамрууллаа.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Бэлэн бай” нөлөөллийн аяны хүрээнд Онцгой байдлын ерөнхий газраас өгсөн постерын дагуу QR код бүхий “Бэлэн бай” баннерыг 4.30:3 хэмжээтэйгээр Онцгой байдлын газрын хажууд 4 замын уулзвар, Спорт ордны эсрэг талд 2 ширхгийг байршуулсан.

Онцгой байдлын газрын алба хаагчдын гэр бүл, дотны хүмүүсийг зөв мэдээлэл зөвхөн таныг биш гэр бүл, найз нөхөд, хайртай бүхнийг тань ХАМГААЛНА уриалгыг дэвшүүлж бүх алба хаагчид өөрсдийн цахим хаягийн профайл зургийг “Бэлэн бай” frame үүсгэж өөрчилсөн. Нийт 52 алба хаагч профайл зургаа шинэчилсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газраас бэлтгэн гаргасан постер мэдээллийг байгууллагын цахим хаягт байршуулан алба хаагчид өөрсдийн цахим хуудсанд түгээн иргэдийг Бэлэн бай аянд нэгдэхийг уриаллаа. 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 06 дугаар 02-ны өдөр хүртэлх хугацаанд давхардсан тоогоор 624 алба хаагч 278 like, 749 share хийсэн байна.

Болзошгүй газар хөдлөлтийн аюулаас сэрэмжлүүлэх, нийт иргэдийг эрсдэлээс хамгаалах, мэдээллээр хангах зорилгоор Зуунмод сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн 258 самбарт "Бэлэн бай" QR код бүхий хэвлэмэл хуудсыг байршууллаа.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар Сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран 2023 оны зургаадугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулах стратегийн команд штабын сургуулийн хүрээнд Онцгой байдлын газраас аймгийн Онцгой комисс, Гамшгаас хамгаалах албадын удирдах бүрэлдэхүүнд "Ослын удирдлагын тогтолцоо" сэдэвт сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 222 хүнийг хамруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх" журмын хүрээнд гамшгаас хамгаалах зарлан мэдээллийн дохиогоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах алба 17, мэргэжлийн анги 26, 27 сумын ард иргэдийг хамруулан ажиллалаа. Тус арга хэмжээнд нийт 12552 иргэнийг хамруулсан.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 32 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 12 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 5 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 9 удаа нийт 26 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа. Мөн байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээний постер, бичлэгүүдийг цаг тухай бүр хийн нийт 10 төрлийн постер 7 төрлийн видео бичлэгийг байршуулсан.

Орон нутгийн TBS болон ТӨВ телевизэд "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг сурталчлах ажлын хүрээнд цаг үеийн холбогдолтой танилцуулга мэдээлэл 3, нэвтрүүлэг 1, ярилцлага 1 бэлтгэн, олон нийтэд хүргэсэн. Мөн 4 төрлийн шторкийг өдөрт 32 удаагийн давтамжтайгаар 15 хоног нийт 480 удаа нэвтрүүлсэн.

Тус арга хэмжээний хүрээнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага 1523 ширхгийг, өрхийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, бэлэн байдлын төлөвлөгөө 986 ширхгийг нийт 2509 ширхэг гарын авлага, зөвлөмжийг тараалаа.

Объектын гал түймэр-5, үер-2, Мал, амьтны гоц халдварт өвчин-5, эрэн хайх-3 нийт 13 дуудлага, мэдээлэл хүлээн авч, гал түймэр унтраах, эрэн хайх аврах, хор уршиг арилгах үйл ажиллагаанд онцгой байдлын газраас давхардсан тоогоор 27 алба хаагч, эрэлч нохой-1, 5 техник, орон нутгийн иргэд-39, 7 техниктэй аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын 65 захирамж, 23 гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгч, гэрээний төсөл боловсруулж ажиллалаа.

Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Давж заалдах шатны шүүх, сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх хуралд аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 6 удаагийн шүүх хуралд оролцлоо.

Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журмын дагуу аймаг, сум, багийн нийт 112 эрх бүхий албан тушаалтны 114 тамгыг шинэчлэх ажлыг зохион байгуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 69 эрх бүхий албан тушаалтны тамганд зөвшөөрөл авч, хууль журмын хэрэгжилтийг хангууллаа.

Авлигатай тэмцэх газраас улс орон даяар хэрэгжүүлж буй "Нэгдье" арга хэмжээнд төрийн 164 байгууллага, нэгдэж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албатай хамтран аймгийн төвийн нийтийн эзэмшил 4 байршилд зурагт хуудас, самбар байршуулж олон нийтэд сурталчиллаа. Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууь, эрх зүйн хэлтсийн пэйж хуудсаар дамжуулан 12 төрлийн постер, шторкийг байршуулж 2000 иргэнийг мэдээ, мэдээллээр хангалаа. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Авлигын хор хөнөөл" сэдвээр Ерөнхий боловсролын сургуулийн 150 сурагчдад сургалт зохион байгуулж эрх зүйн мэдлэгийг дээшлүүллээ.

Аймгийн хэмжээнд зам, тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 2023 оны А/ 405 дугаар захирамжаар “Гэрлээ шилжүүлье” аяныг 07 сарын 1-нээс 09 сарын 1-ний өдрийн хүртэл 2 сарын хугацаатай зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангалаа. Зуунмод-Чингис хаан Олон Улсын нисэх онгоцны буудлын уулзварт хурд сааруулагч хийх төсвийн асуудлыг шийдвэрлүүллээ.

Аймгийн төв, зуунмод сумын “Цагдаа-Олон нийтийн төв”-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр орон нутгийн төсвөөс 20,0 сая төгрөгийг шийдвэрлэн урсгал засварыг ажлыг эхлүүллээ.

Аймгийн Нийтийн номын сан, Манзушир хутагтын Дашчойнхорлин хийдтэй хамтран “Бүтээлээр амилсан Төв аймагчууд” үзэсгэлэнг дэглэж, 352 иргэнд сурталчилж ажиллалаа.

Газар тариалангийн хүрээнд: Хаврын тариалантын ажлыг эрчимжүүлэх технологийн зөрчилгүй хэвийн явуулахад анхаарч 11 сумын 400 орчим тариаланч 16 ААН-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Энэ жил нийт 136.4 мян.га-д тариалж, 355.3 мянган тн ургац хураан авахаар төлөвлөсөн. Үүнд: Үр тариа 78.6 мянган га-аас 110.6 мянган тн, Улаанбуудай 71.6 мянган га-аас 100.9 мянган тн, Төмс 12.5 мянган га-аас 150.0 мянган тн, Хүнсний ногоо 2.0 мянган га-аас 25.5 мянган тн, Тэжээлийн ургамал 24.0 мянган га-аас 60.0 мянган тн тус тус төлөвлөсөн. Өнөөдрийн байдлаар: Үр тариа **57014** га, Улаанбуудай **50352** га, төмс **11188** га, хүнсний ногоо **2166** га, таримал тэжээл **9020** га, тосны ургамал **25623** га-д тус тус тариалаад байна. Аймгийн хэмжээгээр **105011** га-д тариалалт хийгдэж явц 77.1 хувьтай байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зээлийг **ХААН банк** 162 иргэн ААН-ээс 17 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт авснаас 8 тэрбум төгрөгийн зээлийг шийдвэрлэж олгосон. Бусад нь судлагдаж байна. ХААДС-аас таримал тэжээлийн үрийн дэмжлэгээр олгож буй 130тн овъёос, 720тн улаан буудай, 1850кг царгасны үрийг 8 сумын 49 тариалан эрхлэгчид олгуулахаар захиалга, хувиарыг хргүүлэн олгуулж байна.

ХХААХҮЯ-с 478 987 275 төгрөгний 13 төрлийн хүнсний ногооны үрийг хүлээн авч 27 суманд нийт 170 га талбайд тариалах 21 тн үрийг олгосон. Энэ жилийн тариалалтад нийт 9075 тн улаанбуудайны үр шаардлагатай байгаагаас 2022 оны ургацаас 5900 тн үр нөөцөлсөн. Дутагдах үрийг ХААДСангаас нийлүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 30 хувийн урьдчилгаатай зээлээр 66 аж ахуйн нэгж, иргэн, 3100 тн үр татан

авсан байна. Таримал тэжээлийн үрийг Милл хаус, Алейнка, Од групп, Пример агро ХХКомпаниуд нийлүүлж байна.

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хүрээнд: Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 5 аж ахуйн нэгжид 808.6 сая төгрөг, Аймгийн хөгжлийн сангаас 12 аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд 525.0 сая төгрөг нийт 17 иргэн аж ахуйн нэгжид 1336.5 сая төгрөгийн зээл олголоо. ХХААХҮЯам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГазар, Хөгжлийн шийдэл ТББ BEST сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан “5Х” сургалт 13 хоршоо хамрагдаж төгслөө.

ЗУРГАА. СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Стандарт хэмжил зүй, хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын хүрээнд: Угтаалцайдам, Баянцогт сумын 12 худалдаа, 3 нийтийн хоолны үйлчилгээнд тохирлын үнэлгээнд хамруулж Аргалант, Баян, Баянцогт, Баянчандмань, Баян-өнжүүл, Баянжаргалан, Борнуур, Жаргалант, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Угтаалцайдам, Сүмбэр, Сэргэлэн, Зуунмод, Эрдэнэ, Эрдэнэсант сумын худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, гатахуун түгээх газар, эрүүл мэндийн газрын хэмжлийн 3 төрлөөр 208 ширхэг хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажууллаа.

Итгэмжлэгдсэн лабораторийн хүрээнд: Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, чихэр, жимсний чанамал, талх, нарийн боов, гүний ус, хөрс, сав баглаа боодлын нийт 76 сорьц хүлээн авч 373 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулж, улаан буудайн 2 сорьц 8 үзүүлэлтээр лаборатори хоорондын шинжилгээг хийж хянаж, баталгаажууллаа.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02, аймгийн Засаг даргын 01 дугаар албан даалгаварын хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж, байгаль орчин аялал жуулчлалын яаманд хэрэгжилтийг хүргүүлэн ажиллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан удирдамжийн дагуу Эрдэнэ, Баян, Сэргэлэн, Баянцагаан, Баян-өнжүүл, Баянчандмань, Жаргалант, Заамар сумдад уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт, шинжилгээний ажлыг орчны хяналт шинжилгээний газартай хамтран зохион байгууллаа.

2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр монгол тарвага сэргээн нутагшуулах ажлын хэсгийн хамт тарвага нутагшуулах газрын байршлыг сонгох ажил хийгдлээ. Тухайлбал: Баян-өнжүүл сумын Цээл 2-р багийн нутаг Баянгийн уул Сөдөтийн ам, Бүрд 3-р багийн нутаг Халзангийн гол, Өндөрширээт сумын Хайрхан 2-р багийн нутаг Сантын ар гэх газруудад байршуулахаар тогтлоо. Монгол тарвага сэргээн нутагшуулах газрын байршлыг сонгохдоо урьд нь тарвага нутаглаж байсан боловч тоо толгой эрс цөөрсөн, устаж алга болсон зэрэг нөхцөлийг судлан тогтоож, сэргээн нутагшууллаа.

Рашаан төст булгуудын усанд мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх ажлын хүрээнд Эрдэнэсант, Баянцагаан, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл сумдад рашааны дээж цуглуулах ажлыг 6 сарын 27-ноос 30-ны хооронд гүйцэтгэж байна.

Баян, Баянцагаан, Архуст, Баянжаргалан сумдын төвийн ундны усны худагт зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг 2023 оны 6 сарын 26, 27-ний өдрүүдэд Байгаль орчин, аялал жуулчлалын газраас байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авч сумдын засаг даргын тамгын газар хүлээлгэн өгсөн.

Засгийн газрын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны салбарын хяналтын газрын даргын баталсан 01/14 дугаартай удирдамж, Төв аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн А/208 дугаартай захирамжийн хүрээнд Төв аймгийн Эрдэнэ, Баян, Баянцагаан, Сэргэлэн, Баянчандмань, Жаргалант сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 12 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын явцад авсан арга хэмжээ, өгсөн зөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй Петрокоал ХХК-д улсын байцаагчийн 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 31/01-01/073-08 дугаартай актаар үйл ажиллагааг нь түр зогсоож Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 3000 нэгжийн шийтгэл оногдуулан зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны даалгаврыг хүргүүлсэн.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, байгаль орчны аудит хийлгээгүй, ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч гэрээ байгуулаагүй, ахуйн болон

аюултай хог хаягдлаа эрх байгууллагад хүлээлгэн өгдөггүй, хог хаягдлын гэрээ байгуулах, хяналт тавих, аюултай хог хаягдал, гадаад дотоод орчны цэвэрлэгээ хариуцсан нэгж ажилтангүй, аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр нь бүртгээгүй, стандартын шаардлага хангасан нийтийн бие засах газаргүй, бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэдэггүй, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэггүй 11 аж ахуйн нэгж байгууллагад 67 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг тус бүр хүргүүлэн, Зөрчлийн хэрэг нээж 5 сая төгрөгийн торгууль, 1181610 төгрөгийн нөхөн төлбөр оногдуулж барагдуулж ажилласанажилласан.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ХҮРЭЭНД:

Нийгмийн бодлогын хэлтсээс 2023 эхний хагас жилийн байдлаар 5 бодлогын бичиг баримтын тайланг нэгтгэн, хугацаанд нь хяналт үнэлгээний цахим мэдээллийн сан (www.tov.unelgee.gov.mn)-аар тайлагнаж ажиллалаа.

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Соёлын сайд, ХНХ-ын сайд, МУ-ын сайд, Олимп, Нийтийн Биеийн Тамир, Үндэсний хорооны дарга, аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хагас жилийн тайланг нэгтгэн холбогдох яамдуудад хүргүүлсэн.

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан Орон нутгийн өмчит Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах хорооны анхдугаар хуралдааныг зохион байгуулж, хууль журмын дагуу ирүүлсэн материалуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Зуунмод сумын Баруун-Зуунмод ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг хагас жилийн байдлаар дүгнэлээ. Хэрэгжилт 81.55%

Сургалтын байгууллагуудын 2022-2023 оны хичээлийн жилийн тайлан, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайлан, үр дүн, анхаарах асуудлыг хэлэлцэж, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, төлөвлөх, сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тайлант хэлэлцүүлгийг танхим болон цахимаар зохион байгуулж, 29 ЕБС, 37 СӨБ, 2 политехник коллеж, 2 МСҮТ хамрагдлаа.

ЕБС-ийн ЭЕШ-ын явцын үнэлгээ хийж, бэлтгэл ажлыг эрчимжүүлэн, багш сурагчдыг урамшуулан дэмжих зорилгоор УИХ-ын гишүүн Ж.Батжаргалын нэрэмжит “Амжилтын хөтөч” болзолт уралдааныг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж шагналт байр эзэлсэн багш, сурагчдыг урамшуулсан.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах тухай зөвлөмж, чиглэлийг БШУГ, ЕБС-иудад хүргүүлж Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн хичээлийн “Б” байранд аймгийн Засаг даргын 2023 оны А/394 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, 36 хянагч, 8 зохион байгуулагч багшийн дэмжлэгтэйгээр 6 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд “Ахмадын спортын наадам”-ыг “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” уриатай зохион байгуулж, нийт 27 сумын 420 гаруй ахмад тамирчид софт волейбол, ширээний теннис, дартс, граунд гольф, нийтийн цэнгээнт бүжгийн төрлүүдээр өрсөлдөж, аваргуудаа тодрууллаа.

Аймгийн Засаг даргын орлогч бөгөөд “Урлаг, соёлын салбар” хорооны дарга Г.Сурмаа, аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга Д.Мөнхцэцэг, Монгол туургатан театрын захирал нар оролцон баяр наадмын урлаг, соёлын арга хэмжээг хамтран зохион байгуулах ерөнхий найруулагч, зураач, бүжиг дэглээч, уран сайхны удирдаач нартай ажил гүйцэтгэлийн гэрээ байгуулж баяр наадмын бэлтгэл зохион байгуулалтыг ханган ажиллаж байна.

Мөн Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгч, Соён гэгээрүүлэгч, Их зохиолч Дашдоржийн Нацагдоржийн нэрэмжит “Миний Нутаг” яруу найргийн наадмыг Соёл, урлагийн газар, Нийтийн номын сан, Музей, Монгол туургатан театр хамтран зохион байгууллаа.

“Төв сайхан нутгийн шүтээн хайрхан”-ууд уран бүтээлийн төслийг 2022-2023 онд “Эх нутгийн иргэд” ТББ, “Дүнжингаравын зураач уран бүтээлчид” ТББ-аас санаачлан аймгийн ИТХ, ЗДТГ хамтран хэрэгжүүлж 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд нээлтээ хийж, 07 дугаар сарын 01-08ны өдрүүдэд тус музейд, 07 дугаар сарын 26-28 нд аймгийн Монгол туургатан театрт тус тус үзэсгэлэнгээ зохион байгуулна. Тус Үзэсгэлэнд Төв аймгаас төрөн гарсан нэрт зураач уран бүтээлчид аймгийн 27 сумын шүтээн хайрханы уулсыг зурж дүрслэх урлагт мөнхжүүлж оролцож байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Аймгийн хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын байдлаар 380 эх төрж өнгөрсөн оны мөн үеэс 62 тохиолдлоор өссөн, 383 нярай төрсөн. Жирэмсний хяналтад нийт 644 эх, үүнээс 494 жирэмсэн эхийг шинээр хяналтад авч, эхний 3 сартай хяналтад 92.31% хамрагдсан. Нийт үзлэг 151833, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 44716, амбулаторийн үзлэг 89310, идэвхтэй хяналтаар 10744 хүнд үзлэг хийсэн. Түргэн тусламжийн дуудлагаар 6190 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Эмнэлэгт 7304 хүн эмчлэгдэн нийт 53504 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7.3 байна. Аймгийн хэмжээнд нийт 206 нас баралт бүртгэгдсэн, эмнэлгийн нас баралт 20.39%, хорт хавдрын нас баралт 53 тохиолдол буюу 25.73%, гадны шалтгаант нас баралт 35 буюу 16.99%-ийг эзэлж байна.

“Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ өгч, амьдрал бэлэглээ” уриан дор цусны донорын дэлхийн өдрийг тэмдэглэн, тогтмол хугацаанд цусаа бэлэглэгч 100 донорт хүндэтгэл үзүүлээ. Аймагт авлагагүйгээр 100 удаа цусаа бэлэглэж 300 хүний амь насыг аварсан “Мөнгөн донор”-1, 70 удаа цусаа бэлэглэж 210 хүний амь насыг аварсан “Хүрэл донор”-2, “Хүндэт донор”-5 шинээр мэндэллээ.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс хуралдан шинээр 2 эмийн сан, 1 шүдний эмнэлэгт зөвшөөрөл олгосон.

АНЭ-ийн амбулатори тасгийн А, Б блокын дээврийн засвар, АНЭ-т нэн шаардлагатай бүрэн тоноглогдсон автомашин, шаардлагатай 6 төрлийн тоног төхөөрөмж, сумын ЭМТөвүүдэд Нярайн биллиметр аппарат, Нярайн шарлагын аппарат зэрэг 7 төрлийн багаж тоног төхөөрөмжийг улсын төсвөөс шийдвэрлүүлэхээр 2024 оны хөрөнгө оруулалтын программд оруулсан.

Халдварын хяналт, сэргийлэлт:

Ковид-19 цар тахлын эерэг тохиолдлын line лист, орны мэдээ, нөхцөл байдлын мэдээг өдөр бүр нэгтгэн аймгийн удирдлагуудад, ХӨСҮТ, ЭМЯ-д хүргэн ажиллаж байна. 06 дугаар сард 7 эерэг тохиолдол илэрч, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Ойрын хавьтал 25 бүртгэгдсэн байна. Эрүүл мэндийн салбарт гарсан хог хаягдлын мэдээг сар бүр нэгтгэж ХӨСҮТ-д хүргүүлэн ажиллаж байна. Салхин цэцэг, энтеровирус, гар хөл амны өвчин зэрэг халдварт өвчний сэжигтэй 40 тохиолдол бүртгэгдэн, хяналт, эмчилгээнд хамруулсан.

Батсүмбэр суманд бүртгэгдсэн менингококкын халдварын сэжигтэй тохиолдлын ойрын хавьтлыг судлан, хариу арга хэмжээ авч, зөвлөгөө мэдээлэл өгч, илтгэх хуудсыг ХӨСҮТ-ийн Томуугийн үндэсний нэгж руу илгээсэн.

Зуунмод сумын 6 багийн иргэдэд Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг үзлэгийг Эрүүл сүрьеэгүй ирээдүйн төлөө ТББ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, өрхийн Эрүүл мэндийн төв хамтран зохион байгуулж, 1000 гаруй иргэдийг хамруулан, сүрьеэгийн сэжигтэй 4 тохиолдол илрүүлэн, хяналтад авлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд Зуунмод суманд нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулж, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зөв хооллолт, гэр зөвлөмж, амны хөндийн эрүүл ахуй, архи тамхины хэрэглээг бууруулах, эрүүл мэндэд учруулах хор нөлөөг таниулан сурталчлах мэдээлэл сургалт сурталчилгаанд 500 гаруй иргэдийг хамруулан, хүчин төрөгчийн коктейлээр 350 хүүхдэд үйлчиллээ.

Өсвөр үеийнхэний гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг тодорхойлох, түүнд тохирсон нөлөөллийн арга хэмжээг авах зорилгоор БШУГ-тай хамтран ЕБС-ийн 10-12 ангийн сурагчдаас НҮЭМ, ГБТ-ийн чиглэлээр судалгаа авлаа. Судалгаанд аймгийн хэмжээний 21 сургуулийн 828 сурагч /эр 285, эм 534/ хамрагдлаа. Судалгаанд оролцсон сурагчдын 67,1% нь 25-аас дээш насанд, 31,6% нь 22-25 настайдаа хүүхэдтэй болохоор төлөвлөсөн, 24,2% нь хүүхэдтэй үерхдэг, 49,8% нь эцэг эх, асран хамгаалагчтайгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар ярилцдаггүй зэрэг үр дүнгүүд гарч, дүгнэлт хийж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр 8 удаагийн чадавхжуулах сургалт зохион байгуулж, 349 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрууллаа. Улсын хэмжээнд болон орон нутагт зохион байгуулагдсан 7 удаагийн сургалтад 8 эмч, мэргэжилтэн оролцлоо.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ХҮРЭЭНД:

2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтыг Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн хичээлийн “Б” байранд аймгийн Засаг даргын 2023 оны А/394 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, 36 хянагч, 8 зохион байгуулагч багшийн дэмжлэгтэйгээр 06 дугаар

сарын 15-18-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд шалгалтын байранд 741 шалгуулагч шалгуулахаас энэ оны 611 сурагч, өмнөх оны 130 төгсөгч 10 хичээлээр шалгалтад орж шалгалтын ирц-88.3% тай байлаа.

АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭНД:

Баяндэлгэр, Эрдэнэ сумын 2023-2024 оны хичээлийн жилд ажиллах албан бус боловсролын сургалтын танхимын тоног төхөөрөмжийн хангалт, үйл ажиллагаатай танилцан, заавар зөвлөмж өгч ажилласан.

Аймгийн АБНТБТ-ийн удирдлага, багш ажилтнууд Нийслэлийн Багануур дүүргийн Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаатай танилцан туршлага судаллаа.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан Насан туршийн суралцахуй "2022-2023 оны хичээлийн жилийн тайлан" цахим уулзалтад оролцож, Насан туршийн суралцахуйн 2022-2023 оны хичээлийн жилийн зорилго, зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жилийн тайланг сонсож, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хичээлийн жилийн зорилго, зорилтын төсөлд санал солилцлоо. Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн хүрээнд байгууллагынхаа гадна тохижилтын засварын ажлыг зохион байгуулж, цэцгийн мандал шинээр хийлээ.

СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Ардын уран зохиолч, СГЗ Шагдарын Дулмаагийн маркийн нээлтийн арга хэмжээг 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдаж нээлтэд ЗДТГ-ын НБХ-ийн дарга, аймгийн Соёл урлагийн газрын дарга оролцлоо.

"Соёлын сэргэлт-2023" аяны хүрээнд Чингис хаан Үндэсний музейтэй хамтран Төв аймгийн Жаргалант, Батсүмбэр суманд үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Монгол туургатан театр:

Олон улсын хүүхдийн эрхийн өдрийг тохиолдуулан байгууллагынхаа ажилтан албан хаагчдынхаа хүүхэд багачуудад Лев. Устиновын зохиол "МОДОН ЗАМ" хүүхдийн жүжиг тоглогдож, гарын бэлэг гардууллаа.

"Үндэсний ялагч 2023" Улсын 7 дугаар уралдаанд Хөдөлмөрийн Баатар, Төрийн Шагналт, АУЗ Б.Лхагвасүрэнгийн "ХООСОН ЗҮҮД" ганц хүний жүжгээр жүжигчин СТА Б.Сүхбаатар оролцож Дэд байрын шагнал хүртлээ.

Монгол туургатан театраас соён гэгээрлийн чиглэлээр 5 арга хэмжээ зохион байгуулж 1200 үзэгч үүнээс 360 хүүхдэд үйлчилсэн байна.

Монгол Туургатан Театрын нийт 35 алба хаагч 5 жилийн тэтгэмжид хамрагдаж, 163,2 сая төгрөгийн тэтгэмж олгогдлоо.

Нийтийн номын сан:

Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтан "Бүтээлээр мөнхөрсөн Төв аймагчууд" сэдэвт номын үзэсгэлэнг гаргаж, нийт 440 гаруй хүүхэд багачууд, иргэд уншигч үйлчлүүлэгчид үзэж сонирхлоо.

Япон улсын Тоттори мужийн номын сан болон Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн Нийтийн номын сангийн хооронд хамтран ажиллах гэрээний дагуу Тоттори мужийн номын санд 20 ном илгээсэн.

Аймгийн Нийтийн номын сан нь 06 дугаар сард танхимаар 342 байнгын уншигч, 5386 ирэгсэд, 13331 ном олгож уншуулан үйлчиллээ. Үүнээс: 128 эрэгтэй, 214 эмэгтэй уншигч байна. Нийтийн номын сангийн 3 алба хаагчийг 5 жилийн тэтгэмжид хамруулж, 12.7 сая төгрөг олголоо.

Музей:

Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Баян-Өнжүүл сумын уугуул, Монгол Улсын Эрчим хүчний тэргүүний ажилтан, Биеийн тамир спортын тэргүүний ажилтан, Соёлын тэргүүний ажилтан, "Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан" шог зураач Л.Өлзийбатын "ЦАГААН ХЭРЭЭ" үзэсгэлэнгийн нээлтийг 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр аймгийн Музейд дэлгэлээ.

Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг угтан байгууллагын орчны тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд музейн үүдний талбайн цутгалт, хашаа хайс будах, цэцгийн мандал хийж цэцэг тарих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Музейн нийт 7 алба хаагчийг 5 жилийн тэтгэмжид хамруулж, 31,082 сая төгрөг олголоо.

Сумдын Соёлын төв:

Архуст, Баян, Баянхангай зэрэг 10 сумын Соёлын төвүүд нь 57 төрлийн арга хэмээг зохион байгуулж нийт 5381 иргэн үйлчилүүллээ. Аймгийн хэмжээнд 27 сумын Соёлын төвүүдийн 97 албан хаагчийг 5 жилийн тэтгэмжид хамруулж, 452,1 сая төгрөг олгосон.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор явагдаж буй “Монголын баялаг-330” багийн хамт олонтой хамтран сумдын нутаг дэвсгэр дэх түүх соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарыг сурталчилах зорилгоор кино зураг авалтыг амжилттай зохион байгуулан, Монголын үндэсний телевиз болон бусад телевизээр нэвтрүүлэг цацагдаж эхэлсэн.

Баяндэлгэр сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Учиртай гурван толгой дуурь”-ийн олны хэсэг, мөн шинээр “Шувуун саарал” бүжгийн дэглэлт, Үндэсний цөөхүүл хөгжим, морин хуур, найрал дуучдын бэлтгэл зэрэгт нийт давхардсан тоогоор 60 гаруй хүүхэд, уран бүтээлчдийг хамруулан ажиллаж байна.

Сумын соёлын төв байгууллагын гадна өнгө үзэмж сэргээх, бусад засвар үйлчилгээнд 4,1 сая төгрөг зарцууллаа.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД:

Нэг.Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Нэгдүгээрт хүүхэд” уриан дор тэмдэглэн, 8 төрлийн тэмцээн уралдааныг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 443 хүүхэд, оролцож, 6 төрлийн үзвэр үйлчилгээ, чөлөөт арга хэмжээнд давхардсан тоогоор 4200 гаруй хүүхэд залуучууд хамрагдлаа.

Аймгийн Цагдаагийн газар, ГБХЗХГ хамтран ЕБС, СӨБ-ын сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулан эцэг, эх, асран хамгаалагч нарын хүүхдэд тавих хараа хяналтын сайжруулж, хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрсдэлгүй амралт” тусгай арга хэмжээг 27 сумын хэмжээнд зохион байгуулж, үеэр усны аюул, зам тээврийн осол гэмтэл, хурдан морь уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 төрлийн постер мэдээлэл, 1 контентыг олон нийтэд түгээж, ЕБС, ПКоллежийн 500 гаруй суралцагсдад сургалт зохион байгуулж, мэдлэг хандлагыг дээшлүүлсэн.

Дундговь аймгийн “Бүрдийн уянга” зусланд зохион байгуулагдаж буй “Тэгш оролцоо-2023” говийн бүсийн аймгуудын Хүүхдийн чуулганд аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүд, 24 сумын 86 хүүхэд, салааны удирдагч багш нар нийт 103 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын “Хүүхдийн тусламжийн-108” дугаарын утсанд ирсэн нийт 13 дуудлага мэдээллийг хяналтад авч, 46%-ийг шийдвэрлэсэн. Үүнээс бие махбодын хүчирхийлэл-7, үл хайхрах хүчирхийлэл-1, сэтгэл санааны хүчирхийлэл-2, бусад-3 дуудлага байна.

Хоёр.Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

“БИ ГЭР БҮЛДЭЭ ҮҮНИЙГ ХҮСДЭГ” сэдвийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 2 насны ангиллаар гар зургийн уралдаан зарлаж, 50 бүтээлээс 11 хүүхдийн бүтээлийг шалгаруулан, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээний хүрээнд шагнал гардууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр ГБХЗХГ-ын дэргэдэх “Зөвлөгөө өгөх төв” сэтгэл зүйн оношилгоо, зөвлөгөөний багц болон үйлчлүүлэгчид зориулсан 3 насны 3 багц хэрэглэгдэхүүнээр хангагдлаа. Зөвлөгөө өгөх төвөөр ганцаарчилсан зөвлөгөө, ярилцлага 37 хүнд өгч бүлгийн зөвлөгөө- 2 удаа зохион байгууллаа.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, ГБХЗХГ хамтран 2023 онд "Зан үйлээ засах" сургалт зохион байгуулах гэрээ байгуулж, сургалтын төлөвлөгөө баталсан. Төлөвлөгөөний хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн онцлог, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт албадлагын арга хэмжээ авагдсан 7 иргэнд зохион байгуулсан.

Долоо хоног бүрийн Баасан гарагийн 17:00 цагт “ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЦАГ” цахим мэдээллээр “Охиндоо зааж өгөх амьдралын ухаанаас”, “Шалгалтын өмнө өөрийн сэтгэл зүйгээ бэлтгэх, шалгалтын үед анхааралтай ажиллахад туслах зөвлөмж”, “Хүүхдэд эергээр нөлөөлдөг 9 минут” зэрэг 3 сэдвээр иргэдэд мэдээлэл хүргэлээ

Гурав.Залуучуудын хөгжлийн чиглэлээр:

Дугуйтай багш Р.Цэрэнтэй хамтран Зуунмод, Сэргэлэн зэрэг 8 сумын өсвөр үе, залуучуудын дунд “Өөрчлөлтийн менежмент, хувь хүний хөгжлийн менежмент, нийгмийн хөгжил дэвшил” сэдэвт лекцийг үнэ төлбөргүй зохион байгуулж, 358 хүнийг хамруулсан.

Аймгийн Цагдаагийн газрын дэргэдэх Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, ГБХЗХГ-Залуучууд хөгжлийн төв хамтран “Хамтдаа урагшилъя” уриан дор Төв [аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийн](#) дундах шилжин явах цомын төлөөх Гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж, сум, байгууллагын дэргэдэх 12 залуучуудын хөгжлийн зөвлөлийн 90 гаруй тамирчид оролцож шилдгүүдээ шалгаруулсан. Шилжин явах цомын эзнээр Архуст сумын Залуучуудын хөгжлийн зөвлөл шалгарлаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

ЭМДЕГ-тай гэрээ бүхий Төв аймгийн 75 Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн 3,4 тэрбум төгрөгний 217,7 мянга гаруй гүйцэтгэлд хяналт хийж, 753 гүйцэтгэлийн 219 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, зөвлөмж хүргүүлсэн.

Аймгийн Прокурор, Цагдаагийн газарт 28 иргэний ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй авсан тусламж үйлчилгээний судалгааг нэгтгэн хүргүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас “Зүүн хүрээ дээд” сургуультай хамтран зохион байгуулж буй Монгол бичгийн сургалтад цахимаар хэлтсийн хамт олон хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлж байна.

ЭМДЕГ-тай гэрээт аймгийн хэмжээний 45 эмийн сангаас гэрээний үүргээ биелүүлээгүй 4 эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт хийж, 21 эмийн сангийн судалгааг нэгтгэн ЭМДЕГ-т хүргүүлсэн.

ЭМДЕГ-аас зохион байгуулсан “Алхангаа сурталчилая” аяны хүрээнд өглөөний алхалт хийж, 50 гаруй иргэнд эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчилан, мэдээлэл, зөвлөгөө өгч, гарын авлага тараалаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Хяналт шалгалтын чиглэлээр:

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 7 өргөдөл, гомдол, 16 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэлээ.

УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, ЗГ-ын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” тогтоолуудын дагуу Төв аймгийн нийт 14722 өндөр насны тэтгэвэр, 1863 тахир дутуугийн тэтгэвэр авагч, 623 тэжээгчээ алдсаны тэтгэврийг хүн нэг бүрээр бодох, сонгосон цалинг сар бүрээр шинэчлэн тогтоосон итгэлцүүрээр тэтгэвэрийг шинэчлэн тогтоох ажлыг хийж дуусган тогтоолтын хуудсыг хэвлэн тэтгэврийн хувийн хэрэгт баяжилт хийлээ.

Жаргалант, Баяндэлгэр, Лүн, Эрдэнэ, Баянцогт, Аргалант зэрэг сумдын 3220 тэтгэврийн хувийн хэрэгт хяналт шалгалт хийж, тооллого хийлээ.

Дотоодын хяналт, шалгалтын 2023 оны төлөвлөгөөний дагуу Малчин даатгуулагчид тэтгэвэр, тогтооход баримтлах журам, орон тооны бус зөвлөлийн дүрмийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, шалгалтаар 2022 онд орон тооны бус зөвлөлийн хурлаар орсон нийт 66 иргэний материалд хяналт шалгалтыг хийлээ.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын чиглэлээр:

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК 3 удаа хуралдаж, нийт 145 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 15 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 122 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 13 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын актыг цуцаллаа. Буцаасан иргэн 1, хувь хэмжээ нэмсэн 9, хувь хэмжээ бууруулсан 3 иргэн байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурлыг Төв аймгийн Эрдэнэ суманд бүсчлэн зохион байгуулж Мөнгөнморьт, Архуст, Баяндэлгэр, Эрдэнэ, Баянжаргалан, Баян зэрэг 6 сумын 55 хүн оролцлоо. Үүнээс 45 иргэний хөдөлмөрийн чадварыг сунгаж, 1 иргэнийг хувь нэмэгдүүлэн, 4 иргэний хөдөлмөрийн чадварыг хувь бууруулах шийдвэрийг гаргалаа. Дахин шинжилгээ хийлгэхээр 2 иргэнийг буцааж, 2 иргэний хөдөлмөрийн чадварын актыг цуцалж, нэг иргэний сунгалтыг хугацаагүйгээр сунгалаа.

Нийгмийн даатгалын сангийн чиглэлээр:

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 87 даатгуулагчид 186.9 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 71 даатгуулагчид 14.5 сая, ажилгүйдлийн тэтгэмж 96 даатгуулагчид 72.9 сая төгрөг, оршуулгын тэтгэмжинд 15 иргэнд 30,0 сая төгрөг тус тус олголоо.

Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан 17208 тэтгэвэр авагчдад 9,6 тэрбум төгрөгийн тэтгэврийг аймгийн хэмжээнд олгон ажилласан.

Өр авлага барагдуулалтын талаар:

Хуримтлагдсан өрийг барагдуулах ажлын хүрээнд 44 ажил олгогчийн 485 сая төгрөгийн өрийг барагдуулахаар албан шаардлага хүргүүлж, 142 сая төгрөгийн шимтгэлийн өртэй 2 ажил олгогчийн банкин дахь дансны зарлагын гүйлгээг хааж, 14 ажил олгогчийн 419,3 сая төгрөгийн өрийг барагдуулахаар харилцан гэрээ байгууллаа.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

2023 оны 06 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр 1888 иргэнд 3104,5 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1191 иргэнд 625,4 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 16 иргэнд 19,2 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 1204 иргэнд 496,4 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9959 иргэнд 1274,1 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 3883 ахмад настанд 274,5 сая төгрөг, Насны хишиг 5963 иргэнд 963,7 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 735 иргэнд 81,2 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 2337 иргэнд 145,6 сая төгрөг, жирэмсэн 990 эхэд 138,2 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсны тэтгэмж 4222 иргэнд 1054,0 сая төгрөг, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж 311 иргэнд 333,3 сая төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмж 12 иргэнд 24 сая төгрөг, Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 32947 хүүхдэд 1922,2 сая төгрөг тус тус олгосон.

Шинээр төрсөн 68 хүүхдийн мэдээллийг и-халамж системээр бүртгэж, Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой журам, чиглэлийн талаар 60 гаруй иргэнд мэдээлэл өглөө.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 431 өрхийн 1136 иргэн 1201 хүүхдэд 145,6 сая төгрөгийн 10-н нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийллээ.

Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг шинэчилсэн аргачлалаар мэдээлэл цуглуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж 27 сумын 597 өрхийг хамрууллаа.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 06 дугаар сард 6 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааг сунгаж, 5 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааг тогтоолоо. Нийт 11 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хамрагддаггүй 1 хүүхдийг хувилбарт сургалт, цэцэрлэгт хамруулах талаар холбогдох байгууллагуудад чиглэл өглөө.

“Тэмүүлэл” ТББ-тай хамтран “21 аймаг 21 тэргэнцэр” аяныг зохион байгуулан, хөгжлийн бэрхшээлтэй 25 иргэн оролцож, тэргэнцэр шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд тэргэнцэр гардуулан өглөө.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнүүдийн хүрээнд 6 дугаар сарын байдлаар 24 сумын 89 төсөлд 640,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олголоо.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 9 сумын 112 иргэн түр ажлын байранд ажиллаж ХЭДСангаас 40,3 сая төгрөг, Мод тарих үйл ажиллагааны хүрээнд 6 суманд 26,8га талбайд 8480 ш мод бутыг тариалж түр ажлын байраар 58 иргэнийг хангаж ХЭДСангаас 20,8 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо.

Тайлант хугацаанд 130 иргэний 41761.6 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСанд төвлөрч, өссөн дүнгээр 358 иргэний 337394.6 мянган төгрөг төвлөрүүллээ.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн Ejob программд 6-р сарын байдлаар 42 ажил олгогч, 152 иргэн ажил хайгчаар бүртгэгдлээ.

Нийт 18 ажил олгогчийн 51 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 36 /нийт 190/ иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.

Шинээр бий болсон 136 ажлын байрыг бүртгэн баталгаажуулснаас түр шинэ ажлын байр 61, улирлын ажлын байр 19, байнгын шинэ ажлын байр 86 бүртгэгдлээ. /нийт ШАБ 386 үүнээс: байнгын шинэ ажлын байр - 238, улирлын шинэ ажлын байр -24, түр шинэ ажлын байр - 124/ бий болсон байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг Зуунмод Политехник коллеж, Баянчандмань Политехник коллеж, Эрдэнэ, Заамар сумын МСҮТөвд зохион байгуулж ажиллалаа. Улсын үзлэгийн хяналт шалгалтаар ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг баталж, шийдвэрлүүлээгүй, сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалт зохион байгуулах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулдаггүй, үр дүнг тооцдоггүй, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдлыг судлах комисс байхгүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрснийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХҮРЭЭНД:

Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Эрийн 3 наадмын 1 төрөл болох үндэсний Сурын харвааг хөгжүүлэх, өсвөрийн залуу харваачдыг бэлтгэх зорилгоор Мөнгөнморьт сумын "МӨНГӨН ХАВЧААХАЙ" үндэсний сурын холбоонд 4 ширхэг сургалтын иж бүрэн нум, сум, эрхийвч, хасаа гардууллаа. Түүхт 100 жилийн ойг угтан байгууллагын гадна өнгө үзэмжийг сайжруулах, засвар үйлчилгээ хийх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг албан хаагчдын хүчээр хийж гүйцэтгэсэн.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр байгууллагын албан хаагчдын 30 хүүхдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг өгөх үйл ажиллагаанд 1.4 сая төгрөг зарцууллаа

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд 2 насны ангиллаар хүүхдүүдийн дунд 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, хөл бөмбөгийн жонглёрын тэмцээн, гир өргөх тэмцээнүүдийг зохион байгуулж 220 хүүхэд хамруулсан.

Зүүн, баруун бүсээс шалгарсан шилдэг 8 багийн шигшээ тоглолт зохион байгуулагдан эрэгтэй 8, эмэгтэй 4 багийн 116 тамирчин оролцсон

Олон улсын дугуйн өдрийн хүрээнд Монголын дугуйн холбоотой хамтран зохион байгуулсан Дугуйн аялалд 120 тамирчин оролцлоо.

2023 оны "Мини волейболын аймгийн аварга" шалгаруулах тэмцээн Эрдэнэ суманд зохион байгуулж 10 сумын 13 сургуулийн 10-12, 13-14 насны ангилалд охидын 50, хөвгүүдийн 47 багийн 485 тамирчин оролцлоо.

1991, 1997 онд аймагт 10-р анги төгссөн төгсөгчдийн дунд зохион байгуулагдсан спортын наадамд нийт 47 багийн 500 гаруй тамирчид оролцлоо.

"Зуунмод марафон-2023" бүх нийтийн марофон гүйлтийг Зуунмод сумын ЗДТГ-тай хамтран нээлттэй хэлбэрээр зохион байгуулж 6 насны ангилалд 110 хүнийг хамрууллаа.

Үндэсний сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж 6 сумын 36 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.

Нийт 8 удаагийн спортын арга хэмжээнд 156 баг, 1580 гаруй тамирчин оролцсон байна.

06 дугаар сарын 10-18-ны хооронд Киргиз улсын Бишкек хотод зохион байгуулагдсан чөлөөт бөхийн U23 насны ангилалын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс Н.Батбилгүүн алтан медаль хүртлээ. 48 байгууллагын 700 гаруй тамирчид оролцсон Бага насны хүүхдийн таеквондогийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд манай өсвөрийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцож 2 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 2-р байр эзэлсэн.

Монголын хүүхдийн спортын VII их наадам буюу "Монголын хүүхдийн олимп"-д 21 аймаг 9 дүүргээс шалгарсан 5000 гаруй тамирчид спортын 23 төрлөөр 10 хоногийн турш Баянхонгор аймагт өрсөлдсөн. Энэ удаагийн наадамд Төв аймгийн 15 багш дасгалжуулагч, 103 тамирчин спортын 15 төрлөөр /50 эргэтэй, 53 эмэгтэй/, оролцож 6 алт, 18 мөнгө, 13 хүрэл нийт 37 медалийг хүртэж багийн нийлбэр дүнгээр 8-р байрыг эзэлсэн амжилттай оролцлоо. Цаг гаргъя" аяны туг дэвтэр сумдад аялан нийтийг хамарсан биеийн тамирын 82 удаагийн арга хэмжээнд 5966 иргэнийг хамруулсан. Улс, бүс, тив дэлхийн уралдаан тэмцээнээс 9 алт, 20 мөнгө, 16 хүрэл медаль хүртлээ.

НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД

Цэргийн штабын 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн цэргийн анхан шатны сургалтыг 2023 оны 6-р сарын 08 -наас 10 хоногийн хугацаатай Батлан хамгаалахын сайдын баталсан Цэргийн дүйцүүлэх албаны сургалтын хөтөлбөрийн дагуу хээрийн байрлалд байрлуулан, 9 сумын 60 иргэнийг хамруулав.

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургуулийн бэлтгэл ажлыг хангуулах, томилгоот бүрэлдэхүүний тодотгол хийх тэдний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх онол

дадлагын сургуулийг Эрдэнэ суманд 2023 оны 05 сарын 23,24 ний өдөр, Сэргэлэн суманд 25,26 ны өдөр, 06 сарын 05,06 өдрүүдэд Зуунмод суманд зохион байгуулсан.

Дайчилгааны тухай хууль, орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх, Дайчилгаатай хээрийн сургууль оролцох бүрэлдэхүүний тодотгол хийх тэдний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 06 сарын 19-ний өдрөөс Аргалант, Батсүмбэр, Баянхангай, Баянцогт, Борнуур, Баянчандмань, Лүн сумдад тус тус сургалт зохион байгуулсан.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР